



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/22

Амардалай

Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2024 оны 02 дугаар хурлын тэмдэглэл, Аймгийн Засаг даргын 2024 оны А/05 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан сумын нийт нутаг дэвсгэрт цасан бүрхүүл тогтон өвөлжилт хүндэрч, амьтдын идэш хоол ховордож цаашид зэрлэг амьтдад зориулж биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2. Бага газрын чулууны ууланд ногоон тэжээл 100 боодол 2,900,000 төгрөг, Байгаль хамгаалагчид 1,2,3 сарын норм АИ-92 бензин 90 л 229,500 төгрөг, том шуудай 30 ширхэг 90,000 төгрөг, ногоон тэжээл зөөх Дизель түлш 90л 333,000 төгрөгийн зардлыг Байгаль хамгаалах сангийн зардлаас зарцуулсугай.

3. Нийт 3,552,500 (Гурван сая таван зуун тавин хоёр мянга таван зуун) төгрөгийг Сумын Байгаль хамгаалах сангаас зориулалтын дагуу гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  М.БАЯРСҮХ

192/01027